

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023/16/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70357955 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.24 № 02

танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМАГ ДАХЬ БҮСИЙН
ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ц.НАРАН-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас 23,017,591.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 679,761.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 391,571.6 мянган төгрөг нийт 24,088,924.9 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс 21,476,303.8 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, 2,613,477.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21,476,303.8 мянган төгрөг буюу төсвийн эрх нээсэн дүнтэй харьцуулахад 83.9 хувьтай байна.

Тайлант онд нийт 28 эмч, сувилагч тус бүрд орон сууцны урьдчилгаа 20,000.0 мянган төгрөг нийт 560,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгожээ.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжиж, зарцуулах төсвийн эрхийг дээд шатны байгууллагаас нээж өгдөг байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Эрүүл мэндийн газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг 95.6 хувьтай гэж үнэлсэн байна.

Тухай аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,429,559,607.16</u>	<u>7,869,852,847.46</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	856,134.51	2,613,477,292.91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	856,134.51	2,613,477,292.91
3121	Төгрөг	856,134.51	2,613,477,292.91
31211	Төрийн сангийн харилцах	856,134.51	2,613,477,292.91
33	АВЛАГА	5,755,408,735.00	3,036,619,600.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,755,408,735.00	3,036,619,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,673,294,737.65	2,219,755,954.55
351	Түүхий эд материал	1,335,033,209.69	1,765,126,622.55
35110	Тусгай зориулалттай материал	1,010,365,576.39	1,105,717,817.39
35130	Эм боох материал	324,667,633.30	659,408,805.16
354	Хангамжийн материал	338,261,527.96	454,629,332.00
35410	Бичиг хэргийн материал	420,000.00	-
35420	Аж ахуйн материал	1,658,910.00	-
35440	Түлш, шатах тослох материал	2,750,603.96	-
35450	Барилгын засварын материал	326,232,104.00	449,162,332.00
35460	Хүнсний материал	1,519,910.00	5,467,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,680,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>34,200,888,028.82</u>	<u>33,969,244,987.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	34,200,888,028.82	33,969,244,987.21
392	Биет хөрөнгө	31,337,168,028.82	31,105,524,987.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	25,691,263,278.03	25,943,002,111.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,802,980,241.85)	(3,886,110,839.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	628,274,338.00	728,951,723.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(518,563,993.02)	(545,614,466.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,218,860,323.05	17,467,490,580.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,079,955,199.22)	(9,003,792,003.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	393,876,034.83	546,492,922.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(284,514,644.28)	(331,065,780.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	210,091,146.00	453,977,109.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(119,183,012.72)	(267,806,369.02)
393	Биет бус хөрөнгө	2,863,720,000.00	2,863,720,000.00
39301	Програм хангамж	9,883,087.00	9,883,087.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,883,087.00)	(9,883,087.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,863,720,000.00	2,863,720,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>41,630,447,635.98</u>	<u>41,839,097,834.67</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>442,990,700.00</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	442,990,700.00	-
413	Өглөг	442,990,700.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	442,990,700.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>41,187,456,935.98</u>	<u>41,839,097,834.67</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	41,187,456,935.98	41,839,097,834.67
51	Засгийн газрын оруулсан капитал/засгийн газрын сан/орон нутгийн сан	10,297,152,047.96	10,297,152,047.96
512	Хуримтлагдсан үр дүн	10,988,460,331.56	11,640,101,230.25
51210	Өмнөх үеийн үр дүн	1,316,965,662.29	10,988,460,331.56
51220	Тайлант үеийн үр дүн	9,671,494,669.27	651,640,898.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,901,844,556.46	19,901,844,556.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>41,630,447,635.98</u>	<u>41,839,097,834.67</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	30,544,646,827.00	25,319,121,314.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,538,434,752.74	4,628,747,104.84
120	Нийтлэг татварын бус орлого	660,452,897.00	4,628,747,104.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	660,452,897.00	4,628,747,104.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	649,387,897.00	613,371,576.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,065,000.00	66,390,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		2,862,182,345.52
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,627,900,312.97	1,086,803,183.32
122	Тусламжийн орлого	6,877,981,855.74	-
122001	Хандив тусламж /дотоод/	6,764,234,922.01	
122002	Хандив тусламж /гадаад/	113,746,933.73	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,006,212,074.26	20,690,374,209.38
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,179,736,678.26	391,471,647.38
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	445,199,000.00	375,779,646.38
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	720,625,828.26	15,692,001.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,911,850.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,826,475,396.00	20,298,902,562.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	21,825,826,396.00	20,298,902,562.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22,500,163,470.70	24,667,480,415.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,500,163,470.70	24,667,480,415.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,777,697,170.70	24,079,358,215.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,864,214,973.37	10,995,186,220.29
210101	Үндсэн цалин	4,450,233,287.16	5,624,022,744.97
210102	Нэмэгдэл	4,267,627,322.72	4,587,926,228.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	362,547,100.00	318,248,397.20
210104	Урамшуулал	783,807,263.49	464,988,849.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,292,540,796.58	1,383,562,151.90

210201	Тэтгэврийн даатгал	934,826,930.59	945,696,736.26
210202	Тэтгэмжийн даатгал	89,408,390.75	111,316,604.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	71,686,208.69	88,478,706.86
210204	Ажилгүйдлийн даатгал	18,418,718.91	21,633,580.44
210205	Эрүүл мэндийн даатгал	178,200,547.64	216,436,524.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	584,131,454.15	676,772,599.91
210301	Гэрэл, цахилгаан	223,024,233.27	259,980,101.52
210302	Түлш, халаалт	151,117,292.88	173,312,531.63
210303	Цэвэр, бохир ус	209,989,928.00	243,479,966.76
2104	Хангамж, бараа материалын зардал	292,005,117.53	526,151,330.39
210401	Бичиг хэрэг	25,241,782.00	51,685,418.00
210402	Тээвэр, шатахуун	102,274,602.69	121,204,240.61
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,414,650.84	18,967,398.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,311,844.00	60,218,982.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,249,200.00	133,058,985.00
210408	Бараа материал акталсны зардал	37,513,038.00	141,016,306.00
2105	Нормативт зардал	6,559,233,469.32	6,270,914,295.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,170,392,120.32	5,729,564,425.12
210502	Хоол, хүнс	368,741,600.00	495,517,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,099,749.00	45,832,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	115,274,174.00	761,164,717.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,841,487.00
210604	Урсгал засвар	115,274,174.00	759,323,230.00
2107	Томилолт, зочны зардал	4,120,035.00	9,259,656.00
210702	Дотоод албан томилолт	4,120,035.00	9,259,656.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,591,420.84	217,388,858.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,138,425.00	106,759,319.80
210803	Даатгалын үйлчилгээ	4,906,622.00	5,981,929.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	863,220.00	908,710.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	319,000.00	429,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,113,929.84	15,500,000.00
210807	Газрын төлбөр	21,717,900.00	21,717,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	33,532,324.00	66,092,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,949,585,729.91	3,238,958,386.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,676,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,943,909,729.91	3,238,958,386.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	722,466,300.00	588,122,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	722,466,300.00	588,122,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	722,466,300.00	588,122,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,044,483,356.30	651,640,898.69
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,044,483,356.30	651,640,898.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	17,934,421,236.26	24,088,924,920.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	660,452,897.00	679,761,576.00
120	Нийтлэг татварын бус орлого	660,452,897.00	679,761,576.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	660,452,897.00	679,761,576.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	649,387,897.00	613,371,576.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,065,000.00	66,390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,273,968,339.26	23,409,163,344.38
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	445,199,000.00	375,779,646.38
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	445,199,000.00	375,779,646.38
1330	Төсвийн захирагчдаас	734,537,678.26	15,692,001.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,911,850.00	
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	720,625,828.26	15,692,001.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,094,231,661.00	23,017,691,697.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	16,094,231,661.00	23,017,691,697.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	17,925,814,301.75	21,331,170,761.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,925,814,301.75	21,331,170,761.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,213,456,701.75	20,740,852,761.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,864,214,973.37	10,995,186,220.29
210101	Үндсэн цалин	4,450,233,287.16	5,624,022,744.97
210102	Нэмэгдэл	4,267,627,322.72	4,587,926,228.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	362,547,100.00	318,248,397.20
210104	Урамшуулал	783,807,263.49	464,988,849.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,292,540,796.58	1,383,562,151.90
210201	Тэтгэврийн даатгал	934,826,930.59	945,696,736.26
210202	Тэтгэмжийн даатгал	89,408,390.75	111,316,604.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	71,686,208.69	88,478,706.76
210204	Ажилгүйдлийн даатгал	18,418,718.91	21,633,580.44
210205	Эрүүл мэндийн даатгал	178,200,547.64	216,436,524.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	584,131,454.15	676,772,599.91
210301	Гэрэл, цахилгаан	223,024,233.27	259,980,101.52
210302	Түлш, халаалт	151,117,292.88	173,312,531.63
210303	Цэвэр, бохир ус	209,989,928.00	243,479,966.76
2104	Хангамж, бараа материалын зардал	244,129,751.69	411,463,103.64
210401	Бичиг хэрэг	17,279,440.00	48,460,818.00
210402	Тээвэр, шатахуун	89,244,006.85	115,162,158.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,414,650.84	19,001,398.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,311,844.00	95,779,744.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	90,879,810.00	133,058,985.00
2105	Нормативт зардал	4,900,292,703.61	6,243,521,086.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,511,201,553.61	5,689,259,176.44

210502	Хоол, хүнс	368,991,401.00	497,839,410.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,099,749.00	56,422,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,034,766.51	795,216,998.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,456,780.00	130,467,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,605,000.00
210604	Урсгал засвар	154,577,986.51	660,144,998.00
2107	Томилолт, зочны зардал	4,120,035.00	9,259,656.00
210702	Дотоод албан томилолт	4,120,035.00	9,259,656.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,591,420.84	220,075,445.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,138,425.00	109,445,906.80
210803	Даатгалын үйлчилгээ	4,906,622.00	5,981,929.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	863,220.00	908,710.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	319,000.00	429,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,113,929.84	15,500,000.00
210807	Газрын төлбөр	21,717,900.00	21,717,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	33,532,324.00	66,092,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,400,800.00	5,795,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,400,800.00	5,795,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	712,357,600.00	590,318,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	712,357,600.00	590,318,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	712,357,600.00	590,318,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>8,606,934.51</u>	<u>2,757,754,158.40</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,750,800.00	145,133,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,750,800.00	145,133,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,750,800.00	145,133,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,750,800.00	145,133,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,750,800.00)</u>	<u>(145,133,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	856,134.51	2,612,621,158.40
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		856,134.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	856,134.51	2,613,477,292.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	1,362,346,005.31	31,561,342,609.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(45,380,343.02)	(45,380,343.02)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	1,316,965,662.29	31,515,962,266.71
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	9,671,494,669.27	9,671,494,669.27
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	10,988,460,331.56	41,187,456,935.98
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	10,988,460,331.56	41,187,456,935.98
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	651,640,898.69	651,640,898.69
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,297,152,047.96	19,901,844,556.46	11,640,101,230.25	41,839,097,834.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,337,225,745.00	16,754,444,558.00	25,596,988,880.80	21,476,303,761.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,337,225,745.00	16,754,444,558.00	25,596,988,880.80	21,476,303,761.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,337,225,745.00	16,754,444,558.00	24,926,888,880.80	20,885,985,761.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,586,958,200.00	9,567,357,324.59	13,706,012,508.67	10,995,186,220.29
210101	Үндсэн цалин	4,391,268,100.00	4,261,476,505.94	6,434,303,623.00	5,624,022,744.97
210102	Нэмэгдэл	4,187,034,700.00	4,187,034,700.00	6,127,769,685.67	4,587,926,228.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	349,965,000.00	349,965,000.00	353,511,000.00	318,248,397.20
210104	Урамшуулал	658,690,400.00	768,881,118.65	790,428,200.00	464,988,849.76
210105	Гэрээт ажлын хөлс				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,433,847,645.00	1,254,026,992.97	2,055,471,013.49	1,383,562,151.90
210201	Тэтгэврийн даатгал	1,089,711,765.00	909,891,112.97	1,506,837,541.24	945,696,736.26
210202	Тэтгэмжийн даатгал	86,033,970.00	86,033,970.00	137,090,093.00	111,316,604.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	68,827,216.00	68,827,216.00	109,680,497.95	88,478,706.76

210204	Ажилгүйдлийн даатгал	17,206,754.00	17,206,754.00	27,418,038.62	21,633,580.44
210205	Эрүүл мэндийн даатгал	172,067,940.00	172,067,940.00	274,444,842.68	216,436,524.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	846,638,000.00	676,772,599.91
210301	Гэрэл, цахилгаан			320,000,000.00	259,980,101.52
210302	Түлш, халаалт			246,638,000.00	173,312,531.63
210303	Цэвэр, бохир ус			280,000,000.00	243,479,966.76
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	447,443,458.64	411,463,103.64
210401	Бичиг хэрэг			55,664,000.00	48,460,818.00
210402	Тээвэр, шатахуун			118,162,158.64	115,162,158.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			20,622,700.00	19,001,398.00
210404	Ном, хэвлэл				
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			97,460,600.00	95,779,744.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			155,534,000.00	133,058,985.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
2105	Нормативт зардал	-	-	6,679,072,700.00	6,243,521,086.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			6,120,123,600.00	5,689,259,176.44
210502	Хоол, хүнс			502,483,000.00	497,839,410.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			56,466,100.00	56,422,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	946,013,200.00	940,349,998.00
210601	Багаж, техник, хэрэгсэл			275,600,000.00	275,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			8,000,000.00	4,605,000.00
210604	Урсгал засвар			662,413,200.00	660,144,998.00
2107	Томилолт, зочны зардал	-	-	11,435,000.00	9,259,656.00
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт			11,435,000.00	9,259,656.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	228,999,500.00	220,075,445.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			128,739,500.00	109,445,906.80

210802	Аудит, багалгаажуулалт, зэрэглэл тогтоох			3,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ			6,000,000.00	5,981,929.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар			1,300,000.00	908,710.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			650,000.00	429,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			15,500,000.00	15,500,000.00
210807	Газрын төлбөр			21,718,000.00	21,717,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж				
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			52,092,000.00	66,092,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,316,419,900.00	5,933,060,240.44	5,803,500.00	5,795,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,316,419,900.00	5,933,060,240.44		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			5,803,500.00	5,795,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	670,100,000.00	590,318,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	670,100,000.00	590,318,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			670,100,000.00	590,318,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,037,225,745.00	16,754,444,558.00	24,785,964,000.00	24,088,924,920.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	391,571,647.38
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				391,571,647.38
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,397,213,945.00	16,093,991,661.00	24,125,964,000.00	23,017,591,697.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,397,213,945.00	16,093,991,661.00	24,125,964,000.00	23,017,591,697.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	640,011,800.00	660,452,897.00	660,000,000.00	679,761,576.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	628,946,800.00	649,387,897.00	593,610,000.00	613,371,576.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,065,000.00	11,065,000.00	66,390,000.00	66,390,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				856,134.51

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		856,134.51	856,134.51	2,613,477,292.91
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	1
610001	Төсвийн байгууллага				1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	505	505	505	505
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	404	404	404	404
620003	Үйлчлэх ажилтан	100	100	100	100

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 141,674.6 мянган төгрөгийн алдааг¹ залруулж тайлагналаа.

Үүнд: Тусгай зориулалтын 141,016.3 мянган төгрөгийн бараа материал акталсан дүнг, бараа материалын тодруулга тайланд худалдан зарцуулснаар тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт орлогыг 658.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 32,796.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 4,925.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 27,871.8 мянган төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Сахилгын шийтгэлтэй 3 албан хаагчдад 2,715.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, эмч, сувилагч нарын баяр тэмдэглэн өнгөрүүлсэн 2,210.0 мянган төгрөг нийт 4,925.2 мянган төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу илүү цагийн тооцооллыг бүртгээгүй, кассын орлогын ордерын дугаарлалт зөрүүтэй, кассын орлогыг өдөр өдөрт нь тушаадаггүй, 2-5 хоногийн давтамжтай орлогыг дансанд төвлөрүүлдэг, орлого төвлөрүүлэхдээ кассад байгаа мөнгийг бүрэн төвлөрүүлдэггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан, ижил мэдээллийг хоёр өөр иргэнээр гүйцэтгүүлж, ажлын хөлс олгосон, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй нэвтрүүлэг бэлтгэсэн зэрэг зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлэв.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-н бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлагнасан /буруу ойлгосон/, хайнга хандсан, /мартсан тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын удирдлага тооллогын комисс, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэлгүй бараа материал актлах тухай тушаал гаргаж, тусгай зориулалтын 3368 нэр төрлийн материалыг акталсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.4-д "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Актлах хөрөнгийн жагсаалтыг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж, актлах хөрөнгийн шийдвэр гаргаж байх.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төлбөрийн баримтгүй тогтмол зардлын гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-д "анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ бүртгэж тайлагнахгүй байх.

Илрүүлэлт: Яаралтай түргэн тусламжийн тасагт ажилладаг 3 жолооч "Жолоочийн тооцооны хуудас"-ыг үнэн зөв, иж бүрэн хөтлөөгүй, спидометрийн заалт, хаашаа явсан, ямар эмчтэй явсан нь тодорхойгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-д "анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бөглөж, зарцуулалтыг хянаж байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв	2	141,674.6	1	658.3	1	141,016.3	2	141,674.6				
Дүн	2	141,674.6	1	658.3	1	141,016.3	2	141,674.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв	10	30,797.0	2	4,925.2	5	25,871.8	3	-				
Дүн	10	30,797.0	2	4,925.2	5	25,871.8	3	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв	1	2,000.0			1	2,000.0		
Дүн	1	2,000.0			1	2,000.0		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

